




HireVue

HireVue нь ажил олгогч болон горилогч талууд нэг дор цугларах шаардлагагүйгээр чанартай ярилцлага хийхэд зориулагдсан цахим систем бөгөөд өргөдөл гаргагчийн урьдчилан бичиж явуулсан видео мэдээллийг ажил олгогч талд цаг алдалгүй хүргэж, саналыг нь авах боломжийг олгодог.



MEET CANDIDATES ANYWHERE
Reduce travel costs



SAVE TIME
Share interviews with key stakeholders and eliminate rounds



ENGAGE MORE CANDIDATES
High-touch experience in less time



LIKE BEING THERE
High quality streaming technology

Гол онцлогууд:

- Цахим технологийн ашиглалтын хамгийн сүүлийн үеийн хөшүүрэг болох хөдөлгөөнт платформ
- Оролцогчдыг хугацаа алдахгүй үнэлэх, дэмжлэг үзүүлэх боломж
- Тодорхой үе шат бүхий, зохион байгуулалттай ярилцлага авах боломжийг олгох асуултууд
- Оролцогч, ажил олгогчдод зориулсан өндөр үнэлгээ бүхий утасны програм
- Оролцогч, ажил олгогчдод үзүүлэх байнгийн дэмжлэх, туслалцаа



Ярилцлага хийх үе шатууд:

Бэлтгэл: Та ярилцлагаа эхлүүлэхээс өмнө танд дараах 2 зүйлс шаардлагатай

- Adobe Flash Player програм
- Камер

Нэвтрэх: Ярилцлагыг дараах замуудаас сонгон эхлүүлэх боломжтой

- “Start Interview” буюу “Ярилцлага эхлүүлэх” товч дээр даргах
- Утсан дээрээ “HireVue App” буюу ярилцлагын системийг татан авах
- app.hirevue.com цахим хаягаар нэвтэрч ярилцлагын кодоо оруулах

Нөхцөл: Ярилцлагыг хэрхэн хялбар, амжилттай хийх талаарх мэдээлэл болон видеог HireVue-н цахим хуудсанд байршуулсан байгаа. Эхлэхийн тулд “Let's Get Started” буюу “Эхлүүлэх” товч дээр дарна уу. Ингэснээр та уг системийг ашиглах нөхцлийг хүлээн зөвшөөрч байна гэж ойлгоно.

Эхлүүлэхийн өмнө: Ярилцлагаа эхлэхийн өмнө та камер болон микрофоноо холбоод Нэвтрэх, Сануулах, Хаах (Allow>Remember>Close) товч дээр дарна уу. Энэ нь таны системийн холболтын хурд, камер, микрофонтой холбоотой эсэхийг автоматаар шалгана. Үүний дараа та ярилцлагад бэлдэж дасгал хийх боломжтой! “Practice Questions” буюу “Асуултад бэлтгэх” хэсгийг сонгож “Press “ буюу “Үргэлжлүүлэх” товч дээр дарна уу.

Дасгал хийх: Энэ нь ярилцлагын үйл явцтай танилцаж, бэлтгэл хийх боломж юм. Бэлэн болсон үедээ “Let's Get Started” буюу “Эхлүүлэх” товч дээр дарна уу. Энд ярилцлагын үндсэн асуултын адил танд асуулттай танилцаад хариулахад бэлтгэх 30 секундын хугацаа өгөгдөнө. Энэ хугацааг хүлээх шаардлагагүй гэж үзвэл та “Start Recording” буюу “Бичлэг эхлүүлэх” товч дээр дарна уу. Үгүй бол бичлэг 30 секундын дараа эхлэх болно.



Тохиргоо: Дасгал хийх нь та өөрийн компьютер болон техник хэрэгслийн тохиргоог шалгах нэгэн боломж юм. Та өөрийн микрофоны тохиргоо болон чанга, сул байгаа зэргийг шалгаж, асуултын дээд талд байрлах “Settings” буюу “Тохиргоо” товч дээр дарж тохируулах боломжтой. Хэрэв таны микрофон, камер ажиллахгүй бол өөр төхөөрөмжөөр солиорой.

Урьдчилан харах: Та техник хэрэгслээ тохируулж, дасгал хийснийхээ дараа “Play” буюу “Тоглуулах” товчийг дарж бичлэгээ харах боломжтой. Ярилцлагад бэлэн болох хүртлээ та хэдэн ч удаа дасгал хийх боломжтой. Үүний тулд “Do Another Practice Question” буюу “Дахин нэг бэлтгэл хийх” товч дээр дараарай. Ярилцлагаа хийхэд бэлэн болсон үедээ та “Continue” буюу “Үргэлжлүүлэх” товч дээр дарна уу.

Ярилцлага: Ярилцлага нь дасгалын асуулттай адил хэлбэртэй байх бөгөөд асуулт бүрт бэлтгэх 30 секунд, асуултад хариулах 3 минут өгөгдөнө. Та үүнээс богино хугацаанд хариулаад дууссан бол “I’m Done” буюу “Би дуусчихлаа” товч дээр дараарай. Бичлэгээ зогсоож, хариултаа хадгалахын тулд “Stop Recording” буюу “Бичлэг зогсоох” товч дээр дараарай. Бүх асуултад хариулж дуусах хүртэл эдгээр алхмууд давтагдана.

Дуусгах: Та ярилцлагын сүүлийн асуултад хариулмагц танд “All Done” буюу “Ярилцлага дууслаа” цонх харагдана. Эцэст нь та ярилцлагаа дууссан болохыг баталгаажуулж “You’re done” буюу “Дууссан” товч дээр дарна уу.

Нэмэлт мэдээллийг [ЭНД](#) дарж аваарай.

Хэрэв танд туслалцаа хэрэгтэй бол бидэнтэй OTRecruitmentTeam@ot.mn хаягаар холбогдоорой.